

# weCare

## ЭРҮҮЛ ЗҮРХ



**ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН  
ИЛРҮҮЛЭГ**

2022 ОНЫ 2,3 САРД  
УВС АЙМАГ

Санхүүжүүлэгч

ХААН БАНК САН

Гүйцэтгэгч

“ЭРҮҮЛ МЭНД ХӨГЖЛИЙН ЗУУН АССОЦИАЦ” НҮТББ  
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ  
УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

## “ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН ИЛРҮҮЛЭГ”

“Эрүүл зүрх” төслийн тайлан

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

## ТАЛАРХАЛ

“Хүүхдийн зүрхний эмгэгийн хяналт, тандалтын тогтолцоог бүрдүүлэх” суурь судалгаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулагч “Хаан банк сан”-ын хамт олон болон хамтран ажилласан Улсын гуравдугаар төв эмнэлэг, Увс аймгийн эрүүл мэндийн газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд төслийн багийн зүгээс гүн талархал илэрхийлье.

Судалгааны баг

## АГУУЛГА

<b>НЭГ. 6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГ ИЛРҮҮЛЭГ СУРГАЛТ, ДАДЛАГА.....</b>	<b>2</b>
<b>ХОЁР. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГАА.....</b>	<b>15</b>
<b>ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭЛТ.....</b>	<b>16</b>
<b>ДӨРӨВ. 6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН ИЛРҮҮЛЭГИЙН ҮР ДҮН.....</b>	<b>17</b>
<b>ТАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН I.....</b>	<b>24</b>
5.1 Зургаан настай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн үр дүн.....	25
5.2 Зүрхний эмгэгийн илрүүлгийн үр дүн.....	33
<b>ЗУРГАА. ҮР ДҮН.....</b>	<b>36</b>
<b>ДОЛОО. ДҮГНЭЛТ.....</b>	<b>50</b>
<b>НАЙМ. ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>51</b>
<b>ХАВСРАЛТ 1.</b>	

## НЭГ. 6 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГ ИЛРҮҮЛЭГ ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Судалгааны багийн нэрс:

Төслийн удирдагч:	О.Чимэдсүрэн, Профессор, АУ-ны доктор, зөвлөх
Зөвлөх:	Т.Мөнхсайхан, МУЕ-ийн зөвлөх, АУ-ны доктор
Зохицуулагч:	Б.Сүхзориг, ЭМХЗА, гүйцэтгэх захирал Н.Тунгалагсайхан, ЭМХЗА, төслийн менежер
Судлаачид:	С.Энхцолмон, ЭМХЗА, Хүүхдийн эмч Н.Баярмаа, УГТЭ, хүүхдийн зүрхний эмч Б.Нандинцэцэг, УГТЭ, зүрхний эмч Н.Дарьсүрэн, АШУҮИС, АУС, ХАТ багш

### Дэмжигч байгууллага:

“ХААН БАНК САН” нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин ажилласан.

### төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн огноо:

2022 оны 2-4 сар

### Хамтран ажилласан баг:

№	Байгууллагын нэр	Овог нэр	Албан тушаал
<b>Эрүүл мэндийн газар</b>			
1	ЭМГ	Н.Алимаа	ЭМГ дарга
2	ЭМГ	Лхагважав Наранцэцэг	Хүүхдийн мэргэжилтэн
3	ЭМГ	Магсаржав Баянмөнх	Халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн
<b>СЭМТ эмч нар</b>			
1	Баруунтуруун	Намсрай Бүрэнцэцэг	ЭМТ-ийн дарга
2	Бөхмөрөн	Мичир Оюунчимэг	ЭМТ-ийн дарга
3	Давст	Баярмагнай Марга	ЭМТ-ийн дарга
4	Завхан	Батмөнх Билгүүндалай	ЭМТ-ийн дарга
5	Зүүнговь	Алагаа Урангоо	ЭМТ-ийн дарга
6	Зүүнхангай	Далай Батжаргал	ЭМТ-ийн дарга
7	Малчин	Банзрагч Ганжууроол	ЭМТ-ийн дарга
8	Наранбулаг	Лхагвасүрэн Билгүүн	ЭМТ-ийн дарга
9	Өлгий	Батжаргал Энхжин	ЭМТ-ийн дарга
10	Өмнөговь	Нямсүрэн Жавзандулам	ЭМТ-ийн дарга
11	Өндөрхангай	Бямбадорж Молор-эрдэнэ	ЭМТ-ийн дарга
12	Сагил	Насанжаргал Насанжаргал	ЭМТ-ийн дарга

13	Тариалан	Жаргал Нарантуяа	ЭМТ-ийн дарга
14	Түргэн	Цэвээн Цогнэмэх	ЭМТ-ийн дарга
15	Тэс	Батдэлэг Батзориг	ЭМТ-ийн дарга
16	Ховд	Мөнхзул Ариунсувд	ЭМТ-ийн дарга
17	Хяргас	Болдоо Атарцэцэг	ЭМТ-ийн дарга
18	Цагаанхайрхан	Доржнамжил Бурмаа	ЭМТ-ийн дарга

**Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч нар**

19	НЭ	Цэрэндорж Байгальмаа	Нярайн эмч
20	НЭ	Лхагвасүрэн Золзаяа	Хүүхдийн эмч /Уушиг/
21	НЭ	Норзоо Сэлэнгэ	Хүүхдийн эмч
22	НЭ	Даалхай Батхишиг	Нярайн эмч
23	НЭ	Батсуурь Энхцэцэг	Хүүхэд, өсвөр үеийн эмч
24	НЭ	Бат-очир Хишигмаа	Хүүхдийн эмч / Мэдрэл/
25	НЭ	Бат-очир Байгальмаа	Хүүхдийн эмч
26	НЭ	Тулга Амарзаяа	Зүрх судасны эмч
27	НЭ	Жанчив Эрдэнэцэцэг	Зүрх судасны эмч
28	НЭ	Баярсайхан Дэлгэрмаа	Зүрх судасны эмч

**ӨЭМТ-ийн эмч нар**

29	Бат-үржихүй ӨЭМТ	Батбуян Сумьяа	их эмч
30	Дунцагаан ӨЭМТ	Доржсүрэн Оюун-эрдэнэ	их эмч
31	Мөнхбишрэлт ӨЭМТ	Пүрэвдорж Солонгобаяр	их эмч
32	Элбэг-өгөөж ӨЭМТ	Ганболд Гэрэлтуяа	их эмч

**Увс аймгийн улаангом сумын сургуулийн эмч нар**

33	1-р сургууль	Хандсүрэн Галбаяр	эмч
34	2-р сургууль	Катав Алимаа	эмч
35	3-р сургууль	Доржсүрэн Ганчимэг	эмч
36	4-р сургууль	Гүнчин Орлом	эмч
37	5-р сургууль	Хасуу Ганболор	эмч
38	6-р сургууль	Батсуурь Оюунчимэг	эмч

**1. Судалгааны арга, аргачлал боловсруулах, батлуулах:**

АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хороонд танилцуулж, Судалгааны ажлын сэдэв, аргачлалыг 2022 он 01 сарын 18-ний өдрийн Анагаах ухааны сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимээр хэлэлцүүлэн батлуулсан тул судалгааг явуулах ёс зүйн зөвшөөрөл авсан.

### **Судалгааны загвар ба арга зүй:**

### **Судалгааны загварууд:**

#### **А. КАР – судалгаа**

Судалгааны 1-р зорилтын хүрээнд Увс аймгийн хэмжээнд ажиллаж буй Өрхийн болон Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын хүүхдийн эрүүл мэндийн үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх мэдлэг, дадал ур чадварыг байгуулагад суурилсан агшингийн судалгааны загвараар (facility based cross-sectional design, knowledge-attitude- practice- КАР) судлан, сургалтын хэрэгцээг тогтоов.

#### **Б. Сургалт:**

МДХ тогтоох судалгаанд тулгуурлан анхан шатны эмч, эмнэлгийн ажилтанд хүүхдийн эрүүл мэндийг үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх арга зүйн сургалтанд хамруулна. МДХ-ыг сургалтын өмнө ба дараа үнэлсэн (Pre and post-intervention).

#### **В. Хүүхдийн эрүүл мэндийн үнэлгээ:**

Сургууль ба өрхөд суурилсан-агшингийн судалгааны загвар:

#### **Г. Зүрхний эмгэгийн илрүүлэг:**

Сургуульд суурилсан-агшингийн судалгааны загвар

### **А. Мэдээлэл цуглуулсан арга:**

#### **1. Асуумж – 6 бүлэг**

- 7 нүүр бүхий судалгааны хуудас
- Таниулсан зөвшөөрлийн хуудас
- Мэдлэг шалгах сорил
- Зүрхний цахилгаан бичлэг хийх аргачлал
- Бие бялдарын үнэлгээ дадлага
- Хүүхдийн артерийн даралт үнэлэх дадлага

Анагаах ухааны сургуулийн Хүүхдийн анагаахын тэнхимээр хэлэлцүүлэв.

### **Хүүхдийн зүрхний эмгэгийн илрүүлэг, хяналт**

Төслийн удирдагч: О.Чимэдсүрэн, Профессор, АУ-ны доктор, зөвлөх  
Зөвлөх: Т.Мөнхсайхан, МУЕ-ийн зөвлөх, АУ-ны доктор  
Зохицуулагч: Б.Сүхзориг, ЭМХЗА, гүйцэтгэх захирал  
Судлаачид: Н.Баярмаа, УГТЭ, хүүхдийн зүрхний эмч  
С.Энхцолмон, ЭМЯ  
Н.Дарьсүрэн, АШУҮИС, АВС, ХАТ дадлагажигч багш

### **Үндэслэл:**

- 2020 оны байдлаар Монголчуудын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгал, хоол боловсруулах, зүрх-судасны тогтолцооны өвчин эхний 3 байрыг эзэлж харин нас баралтын хувьд зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт сүүлийн 30 жил эхний байрыг эзэлсээр байна.
- Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад жил бүр 6 нас хүрч сургуульд элсэх үед нь тухайн насны бүх хүүхдийг эрүүл мэндийн цогц үзлэг, ялангуяа зүрхний эмгэг, гажгийг эрт илрүүлэх үзлэг хамруулан хянадаг тогтолцоо бүрдүүлсэн байдаг.
- Эрүүл мэнд хөгжлийн зуун болон УНТЭ баг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны хүүхдүүдэд 2021 оны 9 сард эрүүл мэндийн цогц үзлэг хийхэд тэдний **3.4 хувьд нь зүрхний эмгэг** илэрсэн бөгөөд энэ нь хүүхдийн дунд илрүүлэг нэн чухал байгааг харуулж байна.

## Төсөлт ажлын зорилго

Увс аймгийн харъяат 6 настангуудад зүрхний эмгэгийг эрт илрүүлж, эмгэг бүхий хүүхдийг оношлогоо, эмчилгээний хэрэгцээг тогтоох



## Төсөлт ажлын зорилтууд

1. Увс аймгийн анхан шатны ЭМБ-ын эмч нарын хүүхдийн зүрхний эмгэг, эрүүл мэндийн ерөнхий түвшин тогтоох мэдлэгийн түвшинг тогтоох
2. ӨЭМТ, СЭМТ-ийг түшиглэн 6 настай сурагчдад эрүүл мэндийн байдлыг судлан зүрхний эмгэгийг илрүүлэх, оношлох
3. Үзлэгийн үр дүнд тулгуурлан сурагчдын Е эрүүл мэндийн сан үүсгэн зүрхний эмгэгийн тархалт дээр тулгуурлан лавлагаа шатлалын тусламж үзүүлэх, хянах тогтолцооны загварыг боловсруулах



## Судалгааны загвар ба арга зүй:

### А. КАР – судалгаа

- Судалгааны 1-р зорилтын хүрээнд Увс аймгийн хэмжээнд ажиллаж буй Өрхийн болон Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын хүүхдийн эрүүл мэндийн үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх мэдлэг, дадал ур чадварыг байгуулагад суурилсан агшингийн судалгааны загвараар (facility based cross-sectional design, knowledge-attitude-practice- KAP) судлан, сургалтын хэрэгцээг тогтооно.



## Судалгааны загвар ба арга зүй:

### Б. Сургалт:

- МДХ тогтоох судалгаанд тулгуурлан анхан шатны эмч, эмнэлэгийн ажилтанд хүүхдийн эрүүл мэндийг үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх арга зүйн сургалтанд хамруулна. МДХ-ыг сургалтын өмнө ба дараа үнэлнэ (Pre and post-intervention).

### В. Хүүхдийн эрүүл мэндийн үнэлгээ:

- Сургууль ба өрхөд суурилсан-агшингийн судалгааны загвар

### Г. Зүрхний эмгэгийн илрүүлэг:

- Сургуульд суурилсан-агшингийн судалгааны загвар





## Хамрах хүрээ ба зорилтот бүлэг:

•Увс аймаг нь 89 000 хүн амтай, үүнээс 6 настай нийт 2010 орчим хүүхэд байна. 6 настай хүүхдийн 53 орчим хувь нь аймгийн төвд, харин 47 орчим хувь нь 19 суманд амьдарч байна. Аймгийн хэмжээнд нийт 30 ЕБС байгаа бөгөөд бид 6 настай сурагчдыг сургууль, цэцэрлэгээр, мөн өрхийн бүртгэлд тулгуурлана хамруулна.

•Нэлэнхүй түүврийн аргаар аймгийн хэмжээний 6 настай нийт 2010 хүүхдийг уг судалгаанд бүрэн хамруулахыг зорьно. Хүүхдийг судалгаанд хамруулахдаа эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр, оролцохыг зөвшөөрсөн тохиолдолд хамруулна



## Судалгаанд хамруулах ЭМБ-ын эмч мэргэжилтэн

№	ЭМБ	Эмч	Нийт тоо
1.	АНЭ	Хүүхдийн эмч	6
2.	АНЭ	Зүрхний эмч	3
3.	ЭМГ	Хүүхэд хариуцсан мэргэжилтэн	2
4.	СЭМТ	Хүүхэд хариуцсан эмч	18
5.	ӨЭМТ	Хүүхэд хариуцсан эмч	4
6.	Улаангом ЕБС	Сургуулийн эмч	6
7.	Нийт		40



## Мэдээлэл цуглуулах аргууд:

### •Эмч нарын мэдлэг, дадал хандлагын судалгаа

- КАР – асуумж
- Эмч нарын мэдлэг, дадал, хандлагыг 10 асуулт бүхий сорилоор дүгнэн

### •Сургалтын хөтөлбөр, багийн сургалт – интервенц

- ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарт 2 кредит сургалт хийх
  - Хөтөлбөр
  - Онолын хичээл сэдэв
  - Дадлага хичээл



## Мэдээлэл цуглуулах аргууд:

### • Хүүхдийн өсөлт, хөгжил эрүүл мэндийн үнэлгээ:

- Үзлэгийн карт:
  - Ерөнхий үзлэг
  - Эрхтэн тогтолцооны үзлэг
- Асуумж – эцэг эхээс асуух асуулт
- Хэмжилт:
  - Жин, өндөр, хэвлийн тойрог

### • Зүрхний эмгэг илрүүлэг:

- Үзлэг карт
- Зүрхний цахилгаан бичлэг хийх
- Зүрхний эхо



## Таамаглал

- Хүүхдийн дунд зүрхний эмгэгийн тархалт 2-3 хувь байна
- Орон нутагт хүүхдийн зүрхний эмгэгийг илрүүлэх, хянах нөөц, тогтолцоо хангалтгүй



## Орон нутагт дахь төслийн зохион байгуулалт

Уг төслийг хэрэгжүүлэхдээ сумдын болон аймаг дахь эрүүл мэндийн төвийн хүүхдийн эрүүл мэнд хариуцсан эмч, аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч, ЭМГ-ын хүүхдийн мэргэжилтэнг оролцуулан тэдний ажлын байрны чиг үүргийн хүрээнд хийгддэг хүүхдийн үзлэг, илрүүлэгт тулгуурлан нэгдсэн аргачлал, удирдамжаар ханган ажилласан. Түүнчлэн 6 настай хүүхдийн дийлэнх нь ЕБС, болон цэцэрлэгт байдгийг харгалзан Увс аймгийн ЕБС –ийн захирал, удирдлага, сургуулийн эмчийг уг үйл ажиллагаанд татан оролцуулж ДЭМБ-ын санаачлага болох “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн үндсэн зарчимд тулгуурлан анхан шатны ЭМБ болон ЕБС-ын хамтын оролцоог ханган ажиллаа.

Сумдаас ирсэн эмч, ЕБС-ийн удирдлага, аймгийн НЭ, ЭМГ-ийн болон ЕБС-ийн удирдлагыг хамруулан дорхи хөтөлбөрөөр Увс аймагт төслийн баг ажиллан, сургалт явуулсан.

**Оролцогчид:** АНЭ, ЭМГ,СЭМТ, ӨЭМТ–ийн эмч (хүүхэд хариуцсан)  
ЕБС удирдлага

**Хөтөлбөр:** 2022.02.17-.19

### Хүснэгт 1. Сургалтын нэгдсэн хөтөлбөр

Цаг	Сэдэв	Хэн	Албан тушаал
<b>2022 оны 02 сарын 17-ны өдөр</b>			
8:00 -8:25	Бүртгэл	Зохион байгуулагчид	ЭМХЗА Аймгийн ЭМГ
<b>НЭГДСЭН ХУРАЛДААН 8:30 - 10:30</b> Чиглүүлэгч: О.Чимэдсүрэн, ЭМХЗА зөвлөх			
8:30 – 8:50	Нээлт	Т.Мөнхсайхан	АУ-ны доктор, МУЕ-ийн ЭМ, НБС хариуцсан зөвлөх
		Н.Алимаа	Увс аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
		Ц.Төмөр-очир	УГТЭ захирал, МУ-ын хүний гавьяат эмч
8:50 – 9:10	Зүрхний эмгэгийн илрүүлгийн судалгааны зохион байгуулалт (ЕБС-ийн үүрэг оролцоо)	О.Чимэдсүрэн	АУ-ны доктор, профессор
9:10 – 9:30	Увс аймгийн хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудал	Н.Алимаа	Увс аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
09.30 -09:45	“Эрүүл мэндийн дэмжигч сургууль”	О.Чимэдсүрэн	АУ-ны доктор, профессор
09:45 -10:00	Орчны эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ	Д.Нарансүх	АУ-ны доктор, Захирал Хэлт энд Сэфти Солушинс ХХК

10:00 -10:15	Асуулт хариулт:	Оролцогчид	Зохион байгуулагчид
10:15 -11:00	Цайны завсарлага		Зохион байгуулагчид
<b>Салбар хурал, сургалт: 11:00 – 17:00</b>			
<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГ</b>		<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРЛЫН СУРГУУЛИЙН БАГ</b>	
11:00 – 12:30	Сургалт	11:00 – 12:30	Сургалт, судалгаа
12:30 -14:00	Өдрийн хоол		
14:00 -17:00	Сургалт	14:00 – 17:00	Эрүүл мэндийн үзлэг
<b>2022 оны 2 сарын 18</b>			
9:00 – 12:30	Дадлага	9:00 – 12:30	Эрүүл мэндийн үзлэг
12:30 -14:00	Өдрийн хоол		
14:00 -16:00	Дадлага	14:00 – 16:00	Эрүүл мэндийн үзлэг
16.00 -16.30	Ярилцлага		
16:30-16:40	Хаалт	Зохион байгуулагчид	

Энэ төслийн хүрээнд хүүхдийн зүрхний эмгэгийн илрүүлгийн сургалтаас гадна ЕБС-ын 30 гаруй удирдлага, эмч, нийгмийн ажилтанг хамруулан эрүүл мэндийг дэмжигч сургуулийн зарчим, хүүхдийн өсөлт, хөгжил, эрүүл мэндэд ЕБС-ийн үүрэг оролцооны талаар сургалт явуулж тэднийг аймгийн НЭ, ЭМГ дээр эрүүл мэндийн үзлэг, илрүүлэгт хамруулсан.

### **Зохион байгуулах баг. 2022 оны 2 сарын 08**

#### **Сургалтын хөтөлбөр**

“Увс аймгийн 6 настай хүүхдүүдийн бие бялдрын хөгжлийн үнэлгээ ба зүрхний эмгэгийн илрүүлэг” СЭДЭВТ СУРГАЛТЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГИЙН ХӨТӨЛБӨР

2022.02.17

*Хүснэгт 2. Эмч нарын салбар сургалтын хөтөлбөр*

№	Сургалтын чиглэл	Багш/чиглүүлэгч	Хугацаа
2022 оны 02 сарын 17-ны өдөр			
1.	Бүртгэл		08.00-08.25
2.	Нээлт	Т.Мөнхсайхан, АУ-ны доктор, МУЕ-ийн ЭМ, НБС хариуцсан зөвлөх	08.30-08.50
		Н.Алимаа, Увс аймгийн Эрүүл мэндийн газрын дарга	
		Ц.Төмөр-Очир, УГТЭ-ийн захирал, АУ-ны доктор, дэд профессор	
3.	Зүрхний эмгэгийн илрүүлгийн судалгааны зохион байгуулалт (ЕБС-ийн үүрэг оролцоо)	О.Чимэдсүрэн, АУ-ны доктор, профессор	08:50 – 09:10
4.	Увс аймгийн хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудал	Н.Алимаа, Увс аймгийн Эрүүл мэндийн газрын дарга	09:10 – 09:30
5.	“Эрүүл мэндийн дэмжигч сургууль”	О.Чимэдсүрэн	09:30 – 09.45
6.	Орчны эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ	Д.Нарансүх	09:45-10:00
7.	Асуулт хариулт:	Оролцогчид	10:00 -10:15
Цайны завсарлага			10:15 -11:00
8.	Сургалтын зорилго, зорилт: Зүрхний эмгэгийн илрүүлгийн судалгааны зохион байгуулалт	АУ-ны доктор, профессор О.Чимэдсүрэн	11:00-11:20
9	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдварын үед үзүүлэх тусламж үйлчилгээ	Ц.Төмөр-Очир, УГТЭ захирал, АУ-ны доктор, дэд профессор	11.20-11.40
10.	Сургалтын өмнөх мэдлэг шалгах тест	АУ-ны магистр, АШУҮИС-ийн, ХАТ-ийн багш Н.Дарьсүрэн	11:40-12:00
11.	Асуумж судалгаа, таниулсан зөвшөөрөл хуудсыг бөглөх аргачлал	АУ-ны доктор, профессор О.Чимэдсүрэн	12:00-12.20
Өдрийн хоол			12:30-14:00
12.	Хүүхдийн бие бялдрын хөгжил, үнэлгээ: Онолын мэдээлэл	АУ-ны магистр, АШУҮИС-ийн, ХАТ-ийн багш Н.Дарьсүрэн	14:00-14:30
13.	Хүүхдийн бие бялдрын хөгжил, үнэлгээ: Тохиолдолд суурилсан дадлага	АУ-ны магистр, АШУҮИС-ийн, ХАТ-ийн багш Н.Дарьсүрэн	14.30-14.50
14.	Судалгааны маягт бөглөх аргачлал	АУ-ны магистр, Хүүхдийн эрчимт эмчилгээний ахлах зэргийн эмч С.Энхцолмон	14.50-15.20

15.	Хүүхдийн зүрхний эмгэгийн оношилгоо: Онолын мэдээлэл	УГТЭ-ийн хүүхдийн зүрхний ахлах зэргийн эмч, Н.Баярмаа	15.20-15.50
16.	Хүүхдэд тохиолдох цээжээр өвдөх хам шинж, ялган оношилгоо	УГТЭ-ийн хүүхдийн зүрхний ахлах зэргийн эмч, Н.Баярмаа	15.50-16.20
	Асуулт хариулт		16.20-16.30
2022 оны 02 сарын 18-ны өдөр			
1.	Бүртгэл		09:00-09:10
2.	Хүүхдийн артерийн даралт үзэх, оношилгоо: Онолын мэдээлэл	АУ-ны магистр, АШУҮИС-ийн, ХАТ-ийн багш Н.Дарьсүрэн	09:10-09:40
3.	Хүүхдийн артерийн даралт үзэх, оношилгоо: Тохиолдолд суурилсан дадлага	АУ-ны магистр, Хүүхдийн эрчимт эмчилгээний ахлах зэргийн эмч С.Энхцолмон	9:40-10:10
4.	Хүүхдэд зүрхний цахилгаан бичлэг хийх аргачлал: Онолын мэдээлэл	УГТЭ-ийн хүүхдийн зүрхний ахлах зэргийн эмч, Н.Баярмаа	10:10-10:40
	Цайны завсарлага		10:40-10:50
5.	Хүүхдэд зүрхний цахилгаан бичлэг хийх аргачлал: Дадлага ажил	УГТЭ-ийн хүүхдийн зүрхний ахлах зэргийн эмч, Н.Баярмаа	10:50-11:20
6.	Сургалтын дараах мэдлэг шалгах тест	АУ-ны магистр, АШУҮИС-ийн, ХАТ-ийн багш Н.Дарьсүрэн	11:20-11:50
	Асуулт хариулт		11:50-12:20
	Тестын дүн танилцуулах		12:20-12:30
	Санал, дүгнэлт		12:30-13:00
	Өдрийн хоолны завсарлага		13:00-14:00
	Өрхийн ЭМТ-дээр дадлага ажил хийх		14:00-17:20

Сургалтанд оролцогчдод уг судалгааны аргачлал, зохион байгуулалт, үзлэг хийх, асуумж авах, хүүхдийн зүрхний цахилгаан бичлэг хийх аргуудыг багтаасан гарын авлага, сургалтыг багцыг бэлтгэн түгээсэн.

### Хүснэгт 3. Сургалтын багцад:

1. Гарын авлагын агуулга <ul style="list-style-type: none"><li>- 8 нүүр бүхий хүүхдийн өсөлтийн муруй /охид, хөвгүүд/</li><li>- Артерийн даралтын үнэлгээний хүснэгт</li><li>- Хүүхдийн зүрхийг чагнах гол цэгүүд</li><li>- Зүрхний цахилгаан бичлэгийн цээж болон мөчдийн холболтын байршил</li><li>- Цусны дэлгэрэнгүй шинжилгээний хүүхдийн лавлах утга</li><li>- Цагаан эсийн эгнээний эсүүдийн хүүхдийн лавлах утга</li><li>- Хүүхдийг бие махбодыг үнэлэх амин үзүүлэлтийн лавлах утга</li><li>- Хүүхдийн цагаан эсийн эгнээний эсийн лавлах утга</li><li>- Биеийн өндөр, уртыг хэмжих аргачлал</li></ul>
2. Хавтас /оролцогч/
3. А3 постер / оролцогч /
4. Гэрчилгээ / оролцогч /
5. Энгэрийн тэмдэг / оролцогч /
6. Наадаг стикер / оролцогч /
7. Дэвтэр / оролцогч /
8. Бал / оролцогч /
9. Цамц /зохион байгуулагч/
10. Ажлын үнэмлэх /зохион байгуулагч/
11. Даавуу уут /оролцогч, зохион байгуулагч/



## Зураг SEQ Зураг 1\* ARABIC 1. Сургалтанд оролцогчдын багц

### В. СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

#### - Сургалтанд оролцогчид

Төслийн эхний шат буюу сургалтад Увс аймгийн 19 өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, сургуулийн эмч нар уг төсөл хөтөлбөрт хамрагдан Увс аймгийн төв Улаангом сумын 2022 оны 02 сарын 17-19 өдрүүдэд 6 настай хүүхдийн бие бялдрын үнэлгээг хэрхэн хийх, амин үзүүлэлтийг яаж дүгнэх, хүүхдийн зүрхний эмгэгийг хэрхэн илрүүлэх талаар сургалт хийв. Мөн Увс аймгийн 1 дүгээр дунд сургуулийн 1\* ангийн сурагчдад үзлэг, зүрхний цахилгаан бичлэг хийх дадлага ажил хийлээ. Энэ үзлэгт нийт 30 сурагч хамрагдснаас 3 хүүхдэд зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй илэрлээ.

Сургалтанд хамрагдсан эмч нараас сургалтын өмнө болон дараа хүүхдийн бие бялдарын үнэлгээ хийх аргачлал болон хүүхдийн зүрхний эмгэгийн оношилгооны талаарх мэдлэг шалгах сорил авахад

оролцогчдын тестийн үнэлгээ 51%-аар нэмэгдсэн нь сургалт амжилттай явагдсныг илэрхийлж байна. Нийт 45 эмчид батламж олгосон.



Сургалтын хугацаанд УГТЭ-ийн хүүхдийн зүрхний эмч Н.Баярмаа хөдөө Увс аймагт оршин суудаг зүрхний эмгэг сэжигтэй онош тодруулах шаардлагатай болон зүрхний эмгэгийн улмаас хяналтад байдаг 6 сартайгаас 17 нас хүртэлх 61 хүүхдийг бодит үзлэг, зүрхний хэт авиан оношилгоо хийснээс **анх удаа зүрхний төрөлхийн гажиг оношлогдож байгаа 11 хүүхэд (уушгины артерийн нарийсал, зууван цонх, артерийн битүүрээгүй цорго, тосгуур хоорондын таславчийн цоорхой, ховдол хоорондын таславчын цоорхой г.м) , зүрхний хавхлагын эмгэгтэй 6, зүрхний хэм алдалттай 2, зүрхний төрөлхийн гажиг засах мэс заслын дараах болон хяналтын хүүхэд 21** байсан бөгөөд эдгээрээс **12 хүүхдэд мэс засал эмчилгээ шаардлагатай байгаа нь оношлогдсон байна.** Нийт зүрхний үзлэг хийгдсэн хүүхдүүдийн 34,4%-д шинээр зүрхний эмгэг оношилогдсон Увс аймгийн хүүхдүүдийн дунд зүрхний эмгэг их байгааг харуулж байна. Мөн шинээр оношлогдсон 21 хүүхдийг лавлагаа шатлалын эмнэлгийн

болон орон нутгийн эмчийн хяналтанд авсан ба эдгээр хүүхдийн 57,1% буюу 12 хүүхэд нь зүрхний мэс шаардлагатай хүүхэд байсан ба 2022 оны 4 сард эдгээр хүүхдүүдээс 2 хүүхэд УГТЭ-д зүрхний мэс засалд амжилттай орж бүрэн эрүүлжсэн байна.



## ГЭРЧИЛГЭЭ

ЭРҮҮЛ МЭНД ХӨГЖЛИЙН ЗУУН АССОЦИАЦ

№  
Огноон багц цаг 2.0

нар:

Эрүүл Мэнд Хөгжлийн Зүүн Ассоциаци, УГТЭ нар хамтран  
2022 оны 02 сарын 17,18-нд зохион байгуулсан  
"ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ЭМГЭГИЙН ИАРУУЛАГ"  
садагт сургалтын хоолоборийг бүрэн дүүргэсэн тул ГЭРЧИЛГЭЭ өгөв.

Сургагч багш:

С.Энхцолмон /АУ-ны магистр, Хүүхдийн эрчимт эмчилгээний салаах зэргийн эмч/  
Н.Баярмаа /УГТЭ-ийн хүүхдийн зүрхний салаах зэргийн эмч/  
Н.Дарьсүрэн /АУ-ны магистр, АШУУИС-ийн, ХА-ийн багш/



**Б.Сүхэрийг**

Эрүүл мэнд хөгжлийн зүүн  
ассоциацийн гүйцэтгэх захирал

**Ц.Төмөр-Очир**

Г.О.Шаштигийн нэрэмжит улсын  
сурвалжуулар төв эмнэлэг, захирал

огноо: 2022 /weCare.com.mn/ 18

### Хүснэгт 4. Сумын хүүхэд хариуцсан эмч нар

№	Сум	Овог нэр
1	Баруунтуруун	Намсрай Бүрэнцэцэг
2	Бөхмөрөн	Мичир Оюунчимэг
3	Давст	Баярмагнай Марта
4	Завхан	Батмөнх Билгүүндалай
5	Зүүнговь	Алагаа Урангоо
6	Зүүнхангай	Далай Батжаргал
7	Малчин	Банзрагч Ганжууроол
8	Наранбулаг	Лхагвасүрэн Билгүүн
9	Өлгий	Батжаргал Энхжин
10	Өмнөговь	Нямсүрэн Жавзандулам
11	Өндөрхангай	Бямбадорж Молор-эрдэнэ
12	Сагил	Насанжаргал Насанжаргал
13	Тариалан	Жаргал Нарантуяа
14	Түргэн	Цэвээн Цогнэмэх
15	Тэс	Батдэлэг Батзориг
16	Ховд	Мөнхзул Ариунсүвд
17	Хяргас	Болдоо Атарцэцэг
18	Цагаанхайрхан	Доржнамжил Бурмаа



<b>Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч нар</b>		
<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Мэргэжил</b>
19	Цэрэндорж Байгальмаа	Нярайн эмч
20	Лхагвасүрэн Золзаяа	Хүүхдийн эмч /Уушиг/
21	Норзоо Сэлэнгэ	Хүүхдийн эмч
22	Даалхай Батхишиг	Нярайн эмч
23	Батсуурь Энхцэцэг	Хүүхэд, өсвөр үеийн эмч
24	Бат-очир Хишигмаа	Хүүхдийн эмч / Мэдрэл/
25	Бат-очир Байгальмаа	Хүүхдийн эмч
<b>ЭМГ-ын мэргэжилтэн</b>		
<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Мэргэжил</b>
26	Лхагважав Наранцэцэг	Хүүхдийн мэргэжилтэн
27	Магсаржав Баянмөнх	Халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн
<b>ӨЭМТ-ийн эмч нар</b>		
<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Мэргэжил</b>
28	Батбуян Сумьяа	Бат-үржихүй ӨЭМТ-ийн их эмч
29	Доржсүрэн Оюун-эрдэнэ	Дунцагаан ӨЭМТ-ийн их эмч
30	Пүрэвдорж Солонгобаяр	Мөнхбишрэлт ӨЭМТ-ийн их эмч
31	Ганболд Гэрэлтуяа	Элбэг-өгөөж ӨЭМТ-ийн их эмч
<b>Аймгийн нэгдсэн эмнэлгийн зүрх судасны эмч</b>		
<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Мэргэжил</b>
32	Тулга Амарзаяа	Зүрх судасны эмч
33	Жанчив Эрдэнэцэцэг	Зүрх судасны эмч
34	Баярсайхан Дэлгэрмаа	Зүрх судасны эмч
<b>Увс аймгийн улаангом сумын сургуулийн эмч нар</b>		
<b>№</b>	<b>Овог нэр</b>	<b>Мэргэжил</b>
35	Хандсүрэн Галбаяр	1-р сургуулийн эмч
36	Катав Алимаа	2-р сургуулийн эмч
37	Доржсүрэн Ганчимэг	3-р сургуулийн эмч
38	Гүнчин Орлом	4-р сургуулийн эмч
39	Хасуу Ганболор	5-р сургуулийн эмч
40	Батсуурь Оюунчимэг	6-р сургуулийн эмч

### С. СУДАЛГААНЫ ЯВЦ

Увс аймгийн хэмжээнд 6 настай 2000 орчим хүүхэд байдаг. Тус хүүхдүүдээс сургуульд сурдаг 1502 хүүхдээс 1297 хүүхэд бие бялдрын хөгжлийн үнэлгээ ба зүрхний эмгэгийн илрүүлгийн үзлэгт хамруулаад байна.

Үүнээс татгалзсан 118, өвчтэй-34, Улаанбаатар явсан-7, хөдөө чөлөөтэй-46 хүүхэд байсан байна.



Мөн тус аймгийн хувьд Улаанбаатар хотоос алслагдсан аймгуудийн нэг бөгөөд хаврын улирал болж буй тул малчин иргэдийн 6 настай хүүхдүүдийг үзлэгт хамруулахын тулд сургалтад хамрагдсан эмч нар 30-120 км орчим газар явж явуулын үзлэг хийсэн.



Сургалтад хамрагдсан эмч нар өөрсдийн сум, хороонд харьяалагдах 6 настай хүүхдүүдийг үзлэгт хамруулан үр дүнг 2022.03.14нд Улаанбаатар хотруу шуудангаар хүргүүлээ.



## ХОЁР. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Увс аймгийн хэмжээнд нийт 30 сургуультайгаас 27 захирлаас орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар судалгаа авч түүн дээр дүгнэлт хийж байна.

Увс аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 30 сургуульд нийт 18 мянга орчим сурагчид суралцаж байна. ЭМХЗА судалгааны баг Увс аймгийн эдгээр ЕБС-ийн захирал, сургуулийн эмч нарыг оролцуулан “Эрүүл мэндийг дэмжигч сургууль” –ийн хөгжлийн бодлого, Эрүүл мэнд ба боловсролын байгууллагын хамтын ажиллагаа, сурагчдын эрүүл мэндийн боловсрол, бие бялдрын хөгжлийн үнэлгээний талаар хэлэлцүүлэг хийн, сургуулийн орчны суурь судалгааг эхлүүллээ. Мөн сургуулийн удирдлага, эмч нарыг төрөлжсөн мэргэжлийн эмч (ГССҮТ, УНТЭ, УГТЭ) болон аймгийн НЭ-д эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.



## ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭЛТ

- Увс аймагт ажилласан үйл явцын мэдээг ЭМХЗА-н цахим хуудас болон орон нутгийн зурагтын сувгаар мэдээлэл цацагдаж, эцэг эхчүүдийн оролцоог нэмж байлаа.

### *Хүснэгт 5. Хэвлэл мэдээллээр түгээсэн байдал*

<b>Мэдээ</b>	<b>Он сар</b>	<b>Хүрэлт</b>	<b>Лайк</b>	<b>Хуваалцсан</b>
Нээлт	2022.02.17	12254	49	29
СЭМТ уулзалт	2022.02.19	9738	112	10
ЕБС-ийн удирдлагуудтай уулзалт, үйл ажиллагаа	2022.02.22	2152	22	5
<b>Нийт давхардсан тоогоор нийт 46 970 хүнд хүрсэн байна.</b>				

**ДӨРӨВ. 6 настай хүүхдийн зүрхний эмгэгийн илрүүлгийн үр дүн**

**ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ**

I. ТОВЧИЛСОН НЭРШЛИЙН ЖАГСААЛТ.....	21
II. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ.....	22
III. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТ.....	24
IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ.....	25
СУДАЛГААНД ХАМРУУЛСАН НЭГЖ, ТҮҮВЭРЛЭЛТИЙН ТОО.....	26
V. СУДАЛГААНЫ ҮР ДҮН I.....	27
Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл:.....	27
VI. СУДАЛГААНЫ ҮР ДҮН II /давтан үзлэг/.....	39
VII. ДҮГНЭЛТ.....	52
ХАВСРАЛТ 1.....	54


## **I. ТОВЧИЛСОН НЭРШЛИЙН ЖАГСААЛТ**

<b>АӨЭМТ</b>	Аймгийн өрхийн эрүүл мэндийн төв
<b>НЭ</b>	Нэгдсэн эмнэлэг
<b>ӨЭМТ</b>	Өрхийн эрүүл мэндийн төв
<b>СЭМТ</b>	Сумын эрүүл мэндийн төв
<b>УНТЭ</b>	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
<b>УХТЭ</b>	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
<b>УГТЭ</b>	Улсын гуравдугаар төв эмнэлэг
<b>ХӨСҮТ</b>	Халдварт өвчин судлалын үндэсний төв
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам
<b>ЭМХТ</b>	Эрүүл мэндийн хөгжлийн төв
<b>ЭМХЗА</b>	Эрүүл мэнд хөгжлийн зуун ассоциац
<b>ЭМБ</b>	Эрүүл мэндийн байгууллага
<b>ЭХЭМҮТ</b>	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв



## II. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Манай орны хувьд 2020 оны байдлаар өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгал, хоол боловсруулах, зүрх-судасны тогтолцооны өвчин эхний 3 байрыг эзэлж харин нас баралтын хувьд зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт сүүлийн 30 жилийн турш эхний байрыг эзэлсээр



ирсэн.

Зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт 1950 онд нийт нас баралтын 7.1 хувь, 1985 онд 23.4 хувь, 1995 оноос 30.8 хувийг эзэлж байсан ба 2020 оны байдлаар 36.4 хувь хүрч жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь зүрхний эмгэгийн оношилгоо эмчилгээ, хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатайг харуулж байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын дийлэнх хувийг артерийн даралт ихсэлт,


зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлдэг.

Жилд дундажаар 16.5 мянган хүн нас барж байгаагийн 61 хувь нь эрэгтэйчүүд, 39 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (34.2%), хавдар (24.3%), осол гэмтэл, гадны шалтгаан (16.9%) зонхилж байна.

**Жилд 5650 орчим иргэн зүрх судасны эмгэгийн улмаас нас барж байна.**

Өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй эмгэгт нөлөөлөх гол эрсдэлт хүчин зүйл нь:

- Зохисгүй хоололт
- Хөдөлгөөний дутагдал
- Архи, тамхины хэрэглээг байгааг цаашид анхаарч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүүтэй авч, амьдралын зөв дадал сургах, хэвшүүлэх шаардлагатай байна.



- Зүрх судасны тогтолцооны өвчин-Бүгд
- Хавдар-Бүгд
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг-Бүгд
- Амьсгалын тогтолцооны өвчин-Бүгд
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин-Бүгд
- Халдварт ба шимэгчит зарим өвчин-Бүгд
- Шээс, бэлгийн тогтолцооны эмгэг-Бүгд

Эдгээр эрсдэлт хүчин зүйлс нь хувь хүний зан үйлээс хамаарал бүхий сэргийлж болох хүчин зүйлс тул хүүхэд үеэс нь эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрсдлийг эрт илрүүлэх нь нэн чухал юм.

Монгол улсад 2020 оны байдлаар 114.5 мянган 15 хүртэлх насны хүүхэд байгаа бөгөөд нийт хүн амын 33.2 хувийг эзэлж байна. Хүн амыг гуравны нэгийг эзэлж буй 15 хүртэлх насны хүүхдийн дунд зүрхний эмгэгийн эрт илрүүлэх, оношлох, улмаар эмчилгээнд хамруулах, уг

эмгэгт хүргэдэг эрсдэлийг бууруулах эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг интервенцийг цэцэрлэг,

сургууль, гэр бүлд чиглүүлэн хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад жил бүр 6 нас хүрч сургуульд элсэх үед нь тухайн насны бүх хүүхдийг эрүүл мэндийн цогц үзлэг, ялангуяа зүрхний эмгэг, гажгийг эрт илрүүлэх үзлэг хамруулан хянадаг тогтолцоо бүрдүүлсэн байдаг. Монгол улсын хувьд хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй хавдар, зүрх судасны өвчнийг бууруулах чиглэлээр олон жил үндэсний хөтөлбөр, стратеги хэрэгжүүлж байгаа ч уг эмгэгүүд тэргүүлэх шалтгаан болсон хэвээр тасралтгүй өссөөр байгаа нь одоогийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эрс өөрчлөх, шинэ менежмент бүхий үйл ажиллагаа шаардлагатайг харуулж байна.

Эрүүл мэнд хөгжлийн зуун баг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны хүүхдүүдэд 2021 оны 9 сард эрүүл мэндийн цогц үзлэг хийхэд тэдний **3.4 хувьд нь зүрхний эмгэг** илэрсэн бөгөөд энэ нь хүүхдийн дунд илрүүлэг нэн чухал байгааг харуулж байна.

Хүүхдийн зүрхний мэс заслыг УГТЭ, ЭХЭМҮТ, хувийн хэвшлийн зарим эмнэлэг (Сонгдо, Б.Болдсайхан) хийж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар зүрхний мэс засал хийгдсэн **1500** орчим хүүхдэд **хагалгааны дараах хяналт, зөвөлгөөний нэгдсэн систем, бүртгэлгүй, зүрхний төлөвлөгөөт хагалгаа шаардлагатай 1200** орчим хүүхэд, **яаралтай хагалгаанд орох 600** орчим хүүхэд байгаа хэдий ч энэ асуудлыг цогцоор шийдэх, шаардлагатай тусламжийг цаг алдалгүй хүргэх **үндэсний хэмжээний нэгдсэн тогтолцоо, хяналт тандалтын систем байхгүй** байна.

Эдгээр нөхцөл байдалтай уялдан манай судалгааны баг 6 настангуудыг зүрх судасны эмгэгийн илрүүлэгт хамруулан, эмгэг бүхий хүүхдийн эрт оношлогоо, эмчилгээнд хамруулах, тасралтгүй **хянах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шинжлэх ухааны нотолгоог бүрдүүлэн бодлогын түвшинд шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх зорилгоор уг төслийг боловсруулав.**

### **III. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТ**

#### **ЗОРИЛГО:**

6 настай хүүхдүүдэд зүрхний эмгэгийг эрт илрүүлж, эмгэг бүхий хүүхдийг оношлогоо, эмчилгээнд хамруулан, тасралтгүй хянах нэгдсэн тогтолцоог үндэсний түвшинд бий болгох эхлэлийг тавихаар уг судалгааг хийв.

#### **ЗОРИЛТ:**

1. 2021-2022 оны хичээлийн жилд ЕБС-д шинээр элссэн 6 настай сурагчдын бие бялдарын хөгжлийг үнэлэх
2. Хүүхэд бүрт зүрхний цахилгаан бичлэг хийн зүрхний эмгэгийг эрт илрүүлэх
3. Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэнг дээрх 2 чиглэлээр үзлэг, үнэлгээ хийх арга зүйд сургах
4. Зүрхний цахилгаан бичлэгээр эмгэг өөрчлөлт илэрсэн хүүхдүүдийг зүрхний хэт авиан оношлогоо хийж, хяналтын шатлалыг тодорхой болгох
5. Үнэлгээний үр дүнд тулгуурлан хүүхдийн зүрхний эмгэгийн тандалт, хяналтын үндэсний тогтолцоог бүрдүүлэх

#### IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

##### **Судалгааны загварууд:**

##### **А. КАР – судалгаа**

Судалгааны 1-р зорилтын хүрээнд Увс аймгийн хэмжээнд ажиллаж буй Өрхийн болон Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын хүүхдийн эрүүл мэндийн үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх мэдлэг, дадал ур чадварыг байгуулагад суурилсан агшингийн судалгааны загвараар (facility based cross-sectional design, knowledge-attitude- practice- КАР) судлан, сургалтын хэрэгцээг тогтоов.

##### **Б. Сургалт:**

Мэдлэг дадал хандлага тогтоох судалгаанд тулгуурлан анхан шатны эмч, эмнэлгийн ажилтанд хүүхдийн эрүүл мэндийг үнэлэх, зүрхний эмгэгийг илрүүлэх арга зүйн сургалтанд хамруулна. Мэдлэг дадал хандлагыг сургалтын өмнө ба дараа үнэлсэн. (Pre and post-intervention).

##### **В. Хүүхдийн эрүүл мэндийн үнэлгээ:**

Сургууль ба өрхөд суурилсан-агшингийн судалгааны загвар:

##### **Г. Зүрхний эмгэгийг илрүүлэг:**

Сургуульд суурилсан-агшингийн судалгааны загвар

##### **МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД:**

##### **Эмч нарын мэдлэг, дадал, хандлагын судалгаа**

- КАР-Асуумж
- Эмч нарын мэдлэг, дадал, хандлагыг 10 асуулт бүхий сорилоор дүгнэх

##### **Сургалтын хөтөлбөр, багийн сургалт – Интервенц**

- ӨЭМТ, СЭМТ – ийн эмч нарт 2 кредит сургалт орох
  - Хөтөлбөр
  - Онолын хичээл
  - Дадлага хичээл

##### **Хүүхдийн өсөлт, хөгжил эрүүл мэндийн үнэлгээ**

- Үзлэгийн карт
  - Ерөнхий үзлэг
  - Эрхтэн тогтолцооны үзлэг
- Асуумж – эцэг эхээс асуух
- Хэмжилт
  - Жин, өндөр, хэвлийн тойрог

##### **Зүрхний эмгэг илрүүлэг**

- Үзлэг карт
- Зүрхний цахилгаан бичиг
- Зүрхий хэт авиа

## **СУДАЛГААНД ХАМРУУЛСАН НЭГЖ, ТҮҮВЭРЛЭЛТИЙН ТОО**

Увс аймаг нь 89 000 хүн амтай, үүнээс 6 настай нийт **2010** орчим хүүхэд байна. 6 настай хүүхдийн 53 орчим хувь нь аймгийн төвд харин **47** орчим хувь нь **19** суманд амьдарч байна. Аймгийн хэмжээнд нийт **30 ЕБС** байгаа бөгөөд бид 6 настай сурагчдыг сургууль, цэцэрлэгээр мөн өрхийн бүртгэлд тулгуурлан хамруулав.

**Нэлэнхүй түүврийн** аргаар аймгийн хэмжээний 6 настай нийт **2010** хүүхдийг уг судалгаанд бүрэн хамруулахыг зорив. Хүүхдийг судалгаанд хамруулахдаа эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрлөөр судалгаанд хамруулсан.

### **Судалгаанд хамруулах шалгуур:**

- 2020 оны 1 сарын байдлаар 6 нас хүрсэн
- Увс аймгийн харьяат

### **Хасах шалгуур:**


- Татгалзсан
- Судалгааны хугацаанд орон нутагт байгаагүй

## V. СУДАЛГААНЫ ҮР ДҮН I

### Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл:

Судалгаанд 2015 оны 01 дүгээр сарын 01 нээс 12 сарын 31-нийг хүртэлх хугацаанд төрсөн Увс аймгийн 1309 хүүхэд хамрагдсан. Үүнээс аймгийн төвийн 46.5% (n=609), сумын 53.5% (n=700)

хүүхдүүд  
ба эрэгтэй  
(n=680),  
48.1%  
байна  
(Зураг.10).



байсан  
51.9%  
эмэгтэй  
(n=629)

### Зураг 10. А-Судалгаанд хамрагдсан хүүхдийн хүйс, Б-Харьяаллаар нь харуулбал

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг харьяаллаар нь судалж үзэхэд аймгийн төвийн 2, 4, 5 дугаар сургууль, сумдаас Бөхмөрөн, Зүүнхангай, Завхан, Малчин, Наранбулаг, Өлгий, Түргэн зэрэг нь 90% дээш хувьтай хамруулж чадсан байна.



## 5.1 ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ҮР ДҮН:



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн амин үзүүлэлтийг судлаж үзэхэд зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй хүүхдийн зүрхний цохилтын тоо аль алинд түргэссэн байгаа нь хүүхдүүд үзлэгийн үед сандарсан тайван бус сандарсан байх боломжтой юм хэт олширсон байхгүй. Зүрхний бичлэгт өөрчлөлттэй хүүхдүүдийн дунд амьсгалын тоо нэмэгдэж, артерийн даралт буурч байгаа статистик ач холбогдол бүхий ялгаатай байгаа нь харагдаж байна. (Хүснэгт)

Хүснэгт 6. Амин үзүүлэлтийг зүрхний цахилгаан бичлэгт гарсан өөрчлөлттэй харьцуулан судласан дүн


Үзүүлэлт	Үзүүлэлт			p-value
	ЗЦБ хэвийн (n = 1083)	ЗЦБ өөрчлөлттэй (n = 358)	Нийт (n = 1309)	
	Mean ± SD	Mean ± SD	Mean ± SD	
<b>ЗЦТ</b>	100.13 ± 14.15	100.25 ± 14.15	100.53 ± 14.05	0.359
<b>Амьсгалын тоо</b>	23.39±4.2	24.39±4.4	23.56±4.3	<b>0.008</b>
<b>SpO<sub>2</sub></b>	97.01±1.81	96.36±1.81	96.9±1.89	<b>0.011</b>
<b>АД систол</b>	100.63±13.97	95.28±14.96	99.69±14.29	<b>0.000</b>
<b>АД диастол</b>	64.8±11.5	64.5±14.96	67.97±20.69	<b>0.000</b>
	N (%)	N (%)	N (%)	
<b>Зүрхний цохилтын тоо</b>				
<b>Цөөрсөн Хэвийн</b>	-	-	-	-
<b>Түргэссэн</b>	69(6.4)	14 (6.2)	83 (6.3)	
<b>Амьсгалын тоо</b>	1083 (93.6)	212(93.8)	1226(93.7)	
<b>Цөөрсөн Хэвийн</b>	32(3)	8 (3.5)	40 (3.1)	<b>0.004</b>
<b>Олширсон</b>	740 (68.3)	131(58.0)	871(66.5)	
<b>Артерийн даралт</b>	250 (23.1)	75 (33.2)	325 (24.8)	
<b>Буурсан Хэвийн</b>	254 (23.5)	38 (16.8)	292 (22.3)	0.741
<b>Урьдал</b>	191 (17.6)	23 (10.2)	214 (16.3)	
<b>Ихсэлтийн 1 зэрэг</b>	54 (5.0)	5 (2.2)	59 (4.5)	
<b>Ихсэлтийн 2 зэрэг</b>	49 (4.5)	5 (2.2)	54 (4.1)	
	3(0.3)	-	3 (0.2)	

Бие

бялдрын хөгжлийн үнэлгээгээр авч үзвэл тураалтай 2% (n=29), хэвийн жинтэй 66% (n=865), илүүдэл жинтэй 18% (n=228), таргалалтай 14% (n=185), байгаа нь хөдөө орон нутгийн хүүхдийн дунд ч илүүдэл жин, таргалалт нэмэгдэж байгаа харагдсан. Хүүхдийн өндрийн хувьд намхан 1% (n=17), хэвийн өндөртэй 82.6% (n=1081), хэт өндөр 16% (n=209) байгаа нь таргалалтыг дагаад өндрийн өсөлт явагдаж байгааг илтгэж байна (Зураг. 12, 13).




Бие бялдарын хөгжлийн үнэлгээг хүйсээр нь авч үзвэл хөвгүүдийн дунд илүүдэл жин 11.8% (n=154) байгаа боловч охидуудын дунд таргалалт илүүтэй тохиолдох хандлагатай байна. 16.2% (n=102) (Зураг.14) харин өндрийн хувьд хөвгүүдийн дунд хэт өндөр 20.8% (n=141) байгаа статистик ач холбогдол бүхий ялгаатай байв ( $p=0.000$ ) (Зураг. 15).



Зураг 14. БЖИ хүйсээр нь харуулбал





Ерөнхий үзлэгээр амны хөндийн эрүүл ахуйн хувьд шүд эрүүл 26.3% (n=343), цооролттой **63.4%** (n=829), шүдний бусад эмгэгтэй 1.8% (n=23), гүйлсэн булчирхай томролттой 13.6% (n=178) байгаа нь амны хөндийн эрүүл ахуй хангалтгүй байгааг харуулж байна (Зураг. 16). Амны хөндийн эрүүл ахуй хангалтгүй, шүдний цооролт хүүхдийн дунд их байгаагаас зүрхний олдмол эмгэг болох хавхлагын эмгэг үүсэх, нас биед хүрэх үед амьдралын чанарыг доройтуулах, бүр цаашилбал зүрхний дутагдалд оруулан нас барах эрсдэлтэй тул бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл




ахуйн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг эхэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг байнга хийх шаардлагатай.

Судалгаанд хамрагдсан сурагчдын ерөнхий үзлэгийн үр дүнг аймгийн төв, сумаар нь харьцуулж үзэхэд аймгийн төв хэт өндөр нь 18.5%, илүүдэл жин суманд их 18.6% боловч таргалалт аймгийн төвд 17.3% (p=0.021), харин сумын хүүхдийн дунд шүдний цоорол, гүйлсэн булчирхайн томрол илүүтэй байгаа нь (p=0.000) статистик ач холбогдол бүхий ялгаатай байгааг хүснэгт 6 харагдаж байна.


Хүснэгт 6. Ерөнхий үзлэгийн үр дүнг харьяалалаар нь харуулбал

Ерөнхий үзлэг	Үзүүлэлт	Гэрийн хаяг				P утга
		Сум		Аймаг		
Хүйс	Эм	333	47.6%	296	48.6%	
	Эр	367	52.4%	313	51.4%	
Өндөр	Намхан	9	1.3%	8	1.3%	0.077
	Хэвийн	594	84.9%	487	80.2%	
	Хэт өндөр	97	13.9%	112	18.5%	
Биеийн жингийн индекс	Тураал	17	2.4%	12	2.0%	0.021
	Хэвийн	473	67.6%	392	64.6%	
	Илүүдэл жин	130	18.6%	98	16.1%	
Шүд	Таргалалт	80	11.4%	105	17.3%	0.000
	Хариулаагүй	8	1.1%	106	17.4%	
	Эрүүл	223	31.9%	119	19.5%	
	Шүдний цоорол	465	66.4%	461	59.7%	
Нүд	Бусад	2	0.6%	19	3.1%	0.000
	Хариулаагүй	23	3.3%	201	33.0%	
	Хэвийн	674	96.3%	403	66.2%	
	Нүдний шилтэй	2	0.3%	2	0.3%	
Гүйлсэн булчирхайн хэмжээ	Бусад	1	0.1%	3	0.5%	0.000
	Хариулаагүй	51	7.3%	329	54.0%	
	Хэвийн	532	76.0%	219	35.9%	
	Томорсон	117	16.8%	61	10.0%	

Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн насны хувьд дундаж нас  $28.71 \pm 5.36$  (18-49) нас, 25 настай нь 7.9% (n=103) буюу хамгийн олон байсан бол төрөлтийн тоо хамгийн олон нь 7, дундаж төрөлтийн тоо  $2.29 \pm 1.16$  байлаа. Нийт сурагчдын цэцэрлэгт хамрагдалт 75.1% (n=983), харьяаллын хувьд сумын хүүхдүүд цэцэрлэгт хамрагдалт муу байгаа 70.8% (n=496) нь харагдаж байна. (Зураг 17)



Нэгдүгээр ангийн хүүхдийн дунд амьсгалын замын цочмог халдвар нь 8.5% (n=112) буюу өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байгаа бол харшлын эмгэг 1.6% (n=20) харааны бэрхшээл 1.2% (n=12), сонсголын бэрхшээл 0.6% (n=6) байгааг Зураг 18-аас харагдаж байна.




Нийт судалгаанд оролцогчдын зовуурь илэрч шүдний эмчид үзүүлж байсан 74.1% (n=970), хараагаа шалгуулж байсан 10.4% (n=136) нь сургуульд орохоосоо өмнө нүдний хараагаа шалгуулах нь маш бага байгаа нь нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Сурагчдын дэлгэцийн хэрэглээг судлахад гар утас үздэг 72.3% (n=947), компьютер үздэг 54.2% (n=710), зурагт үздэг 17.5% (n=229) байна. Гэрийн хаягаар нь харьцуулан харахад сумын хүүхдүүдийн дунд гар утас, компьютерын хэрэглээ өндөр байгааг хүснэгт 7-харж байна. (p=0.000, 0.004).


*Хүснэгт 7. Сурагчдын дэлгэцийн хэрэглээ*

Дэлгэцийн төрөл	Гэрийн хаяг		P утга
	Сум	Аймаг	
Компьютер	370 (52.1%)	340 (47.9%)	<b>0.000</b>
Гар утас	526 (55.5%)	370 (44.5%)	<b>0.004</b>
Телевизор	175 (76.4%)	54 (23.6%)	0.054

Гар утасны хэрэглээ сурагчдын хугацаагаар нь үзвэл дундаж нь  $2.44 \pm 1.66(0.1-10)$  цаг өөрөөр хэлбэл хамгийн бага нь 0-10 минут, хамгийн их 10 цаг хүртэл, хамгийн олон давхцаж байгаа нь 2 цаг үздэг байна (Зураг 19). Мөн нийт сурагчдын 9.5% (n=124) нь ямар нэг урлаг спорт болон ямар нэг дугуйланд суралцдаг гэжээ. Тэдгээрийг харьяаллаар нь харьцуулан үзвэл аймгийн төвийн хүүхдүүд 56.5% (n=70) илүү дугуйланд хамрагдаж байгаа нь p=0.000 статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.




